

МОНГОЛЫН СКАУТЫН ХОЛБООНЫ ДҮРЭМ

Монголын Скаутын Холбооны Үндэсний Зөвлөлийн
2008 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хурлаар нэмэлт өөрчлөлт оруулав

УДИРТГАЛ

Скаутын хөдөлгөөнийг анх 1907 онд Английн цэргийн нэрт жанжин Роберт Баден Пауэлл үндэслэсэн бөгөөд эдүгээ 100 гаруй жилийн турш энэхүү хөдөлгөөн дэлхийн янз бүрийн улс үндэстэн, бүс нутагт хөгжиж байна.

Скаутын хөдөлгөөн нь анх энэхүү хөдөлгөөнийг үндэслэгчийн боловсруулсан зорилго, зарчим, аргад нийцүүлэн хүүхэд, залуучуудыг хүмүүжүүлэх, улс төрийн бус, аливаа хүний гарал үүсэл, арьсны өнгө, шашин шүтлэгээс үл хамаарах, нийтэд нээлттэй, сайн дурын хөдөлгөөн мөн.

Скаутын хөдөлгөөний зорилго нь хувь хүний болон үүрэг хариуцлагаа ухамсарласан иргэн, түүнчлэн орон нутгийн хийгээд үндэсний, олон улсын хамтын нийгэмлэгүүдийн гишүүний хувьд оюун ухаан, нийгэм, сэтгэл санааны чадамжаа бүрэн дүүрэн дээшлүүлэхийн тулд өсөж хөгжихөд нь хүүхэд, залуучуудад тус дэмжлэг үзүүлэхэд оршино.

Энэхүү хөдөлгөөний үзэл санаа, зорилго, ач холбогдлыг хүлээн зөвшөөрч өөрийн оронд түгээн дэлгэрүүлэх зорилгоор манай орны нийслэл болон бусад хэд хэдэн аймагт байгуулагдсан скаутын анхны бүлүүд, тэдгээрийн дэмжигчид 1992 оны 4 дүгээр сарын 16-нд Улаанбаатар хотноо хуран цугларч Монголын Скаутын Холбоог зохион байгуулах Их хурлыг хуралдуулсанаар тус байгууллага анх байгуулагдсан юм.

Монголын Скаутын Холбоо нь Дэлхийн Скаутын Хөдөлгөөний Үндсэн хуульд тодорхойлсон зорилго, үндсэн зарчмууд аргыг үндэс болгон Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль, тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулах болно.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

1. Нэр

Тус байгууллага нь "Монголын Скаутын Холбоо" гэж нэрлэгдэнэ.

Албан бичигт "МСХ" гэж товчлон хэрэглэнэ.

Монголын Скаутын Холбоо нь өөрийн бэлгэдэл, онцлог, таних тэмдэг, харилцах данстай байх ба албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

2. Зорилго

Монголын Скаутын Холбооны зорилго нь:

а. Монгол оронд скаутын хөдөлгөөнийг дэлгэрүүлэн хөгжүүлэх.

б. Дэлхийн Скаутын Хөдөлгөөний Байгууллагын бүрэн эрхт, хүлээн зөвшөөрөгдсөн гишүүн байгууллагын хувьд өөртөө оногдсон эрхийг хадгалахын хамт Дэлхийн Скаутын Хөдөлгөөний Удирдах дээд байгууллагуудаас дэвшүүлэх зорилт, шаардлагыг хэрэгжүүлэх.

3. Зарчмууд

Монголын Скаутын Холбоо нь дараах нийтлэг зарчмуудыг үндэс болгоно.

Бурхны өмнө хүлээх үүрэг

Оюун санааны итгэл үнэмшлийн зарчмууд, тэдгээрийг илэрхийлэгч шашинд үнэнч байж, түүнээс үүдэн гарах үүрэг хариуцлагыг сахин биелүүлэх.

Бусдын өмнө хүлээх үүрэг

Төрөлх эх орноо хайрлан дээдлэх үзлийг дэлхий ертөнцийн хөгжил дэвшилтэй хослуулан орон нутаг, улс үндэстэн, олон улсын түвшинд харилцан ойлголцох, хамтран ажиллахыг эрхэмлэх, Улс, нийгмийнхээ хөгжил цэцэглэлтэд гар бие

оролцохдоо Эх орон нэгт хүн ардынхаа алдар хүнд, сайн сайхныг болон байгаль ертөнцийн эвдэршгүй бүрэн бүтэн байдлыг дээдлэн хүндлэх.

Өөрийн өмнө хүлээх үүрэг

Өөрийгөө хөгжүүлэхийн төлөө хариуцлагатай хандах.

4. Скаутын Андгай ба хууль

Скаутын хөдөлгөөнд оролцогч бүх гишүүд нь энэхүү хөдөлгөөнийг үндэслэгчийн боловсруулж, скаутын үндэсний байгууллагууд тус тусын улс үндэстний соёл, иргэншилд нийцүүлэн өөрсдийн эх хэлнээ хөрвүүлж, Дэлхийн Скаутын Хөдөлгөөний Байгууллагаар батлагдсан скаутын Андгай ба Хуульд үнэнч байх ёстой.

Скаутын Андгай

..... овогтой би Бурхны болон эх орныхоо өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, ямар ч үед бусдад туслан, Скаутын хуульд захирагдахад өөрөөсөө хамаарах бүхнийг хийхээ нэр төрөө барин андгайлж байна.

Кабын Андгай

..... овогтой би өдөр бүр сайн үйлс бүтээж, бусдад туслахаа андгайлж байна.

Скаутын Хууль

1. Скаутын нэр төрийг хамгаална.
2. Скаут нь үнэнч шударга байна.
3. Скаут нь эелдэг найрсаг байна.
4. Скаут нь арвич хямгач байна.
5. Скаут нь ахмадаа хүндэлж, тэдний сургамжийг биелүүлнэ.
6. Скаут нь бүх хүний найз, нөхөр байж тэдэнд байнга тусална.
7. Скаут нь байгаль, ан амьтны нөхөр байна.
8. Скаут нь бодол санаа, үг хэл, ажил үйлсээрээ цэвэр ариун байна.
9. Скаут нь ямар ч үед сэтгэл өөдрөг байж, тохиолдсон бэрхшээлийг даван туулах чадвартай байна.

Кабын Хууль

1. Каб нь үнэнч шударга байна.
2. Каб нь эелдэг найрсаг байна.
3. Каб нь ажилч хичээнгүй байна.
4. Каб нь цэвэрч нямбай байна.
5. Каб нь жинхэнэ скаут байхын төлөө хичээн зүтгэнэ.

5. Скаутын арга

Энэ нь дор дурьдсан зүйлээр дамжуулан өөрийгөө боловсруулан хөгжүүлэх нэгдмэл цогц тогтолцоо юм. Үүнд:

- Андгай ба Хуулийг сахин биелүүлэх.
- Ажил үйлийг өөрийн биеэр биечлэн оролцон үйлдэж сурах.
- Анхан шатны нэгжид гишүүн байж (жишээ нь салаа) улмаар аливаа шинэ сэргэг бүхнийг нээхэд оролцож (насанд хүрэгчдийн удирдлагын дор) өөртөө хариуцлага хүлээх, өөрийгөө хянаж сурах бөгөөд энэ бүгд нь зан байдлаа төлөвшүүлэх, эрдэм мэдлэг эзэмших, өөртөө итгэж сурах, бусадтай хамтран ажиллах, мөн бусдыг удирдах авьяас чадварт суралцах, бусдын итгэл найдварыг хүлээж чаддаг болоход чиглэгдэнэ.
- Оролцогчдын хүсэл сонирхолд үндэслэсэн бөгөөд гол төлөв эрүүл агаарт, байгальтай шууд харьцах замаар зохион байгуулах төрөл бүрийн арга хэмжээний (янз бүрийн тоглоом наадам, хүн, нийгэмд ашиг тустай ажил үйлчилгээ үзүүлэх мэдлэг, чадвар, дадал гэх мэт) дэвшүүлэн хөгжүүлэх, урамшуулан дэмжих хөтөлбөрүүд болно.

6. Статус

Монголын Скаутын Холбоо нь өөрийн гишүүдийг тал бүрийн мэдлэг боловсролтой, дадал, чадвартай иргэн болж төлөвшихөд нь туслах замаар нийгмийн хөгжил, дэвшлийн төлөө үйлчлэх төрийн бус байгууллага мөн.

7.Бодлого

Үндэсний болон Дэлхийн Скаутын Байгууллагын зорилгод нийцсэн үйл ажиллагаа явуулж буй аливаа байгууллага, хувь хүнтэй тодорхой асуудлаар хамтран ажиллана.

8. Санхүүжилт

Монголын Скаутын Холбоо нь дараах эх үүсвэрүүдээс санхүүжнэ.

- а. Гишүүний татвар, хандив
- б.Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хандив
- в.Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого

9. Байгууллага татан буугдах тухай

А. Төрийн бус байгууллагын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дугаар заалтыг зөрчсөн тохиолдолд зөвхөн шүүхийн шийдвэрээр татан буугдана.

Б. Скаутын хөдөлгөөний Үндсэн хууль, зарчмуудыг зөрчсөн буюу скаутын арга зарчмаар ажиллаж чадаагүй тохиолдолд Үндэсний Зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхийн саналаар татан буугдаж болно.

В. Шүүхийн шийдвэрээр албадан татан буугдсан тохиолдолд эд хөрөнгийн асуудлыг ТББ-ын тухай хуулийн 7-р дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГИШҮҮНЧЛЭЛ БА ТАТВАР

10. Монголын Скаутын Холбооны гишүүнээр дор дурьдсан насны хүүхэд залуучууд, түүнчлэн скаутын бүх шатны байгууллагад сайн дураар ажиллах хүсэл сонирхолтой янз бүрийн ажил мэргэжлийн насанд хүрэгчид байж болно.

- а) Кабууд — 6-11 насны охид, хөвгүүд
Эдгээр насны охид хөвгүүд нь Монголын Скаутын Холбооны Кабын салбарыг бүрдүүлнэ.
- б) Скаутууд — 12-16 насны охид, хөвгүүд
Эдгээр насны охид, хөвгүүд нь Монголын Скаутын Холбооны Скаутын салбарыг бүрдүүлнэ.
- в) Венчирүүд — 17-18 насны охид, хөвгүүд
Эдгээр насны охид, хөвгүүд нь Монголын Скаутын Холбооны Венчирийн салбарыг бүрдүүлнэ.
- г) Роверууд — 19-25 насны залуучууд
Эдгээр насны залуучууд нь Монголын Скаутын Холбооны Роверын салбарыг бүрдүүлнэ.
- д) Анхан шатны нэгжид ажиллах удирдагчид
- е) Скаутын аль нэгэн байгууллагад тодорхой үүрэгт ажилд сонгогдсон хүмүүс
- ё) Скаутын үйл ажиллагааг дэмжигч насанд хүрэгчид

11. Монголын Скаутын Холбоонд сайн дураар элсэхийг хүсэгчид нь оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ скаутын анхан шатны аль нэгэн нэгжид элсэх тухай хүсэлтээ гаргаж, тодорхой хэсэг хугацаанд зохих шатны сургалт болон үйл ажиллагаанд оролцож скаутын хөдөлгөөний тухай үндсэн мэдлэгтэй болж, андгай өргөснөөр гишүүнээр элссэнд тооцно. Шинээр гишүүнд элсэгчдийг дэлгэрэнгүй бүртгэлд бүртгэнэ. Элсэгч нь скаутын дүрэмт хувцас, онцлох тэмдэг зэргийг хэрэглэх эрхтэй болно.

12. Монголын Скаутын Холбооны гишүүнээс хэн боловч хүссэн цагтаа сайн дураар татгалзах эрхтэй. Гишүүнээс татгалзсанаа бичгээр мэдэгдэж бүртгэлээс хасуулна.

13. Байгууллагын гишүүд нь гишүүний татварыг дараах хэмжээгээр төлнө.

- Удирдах Зөвлөлийн гишүүд – 100.000 төгрөг
- Үндэсий Зөвлөлийн Товчооны гишүүд – 20.000 төгрөг
- Хяналтын Зөвлөлийн гишүүд – 20.000 төгрөг
- Аймаг дүүргийн Скаутын зөвлөлийн Дарга болон сонгуульт гишүүд, дэмжигчид – 5.000 төгрөг
- Анхан шатны нэгжийн удирдагч, гишүүд – 1.500 төгрөг
- Каб, скаут, венчир, роверууд – 1.000 төгрөг

а) Скаутын Зөвлөл бүр гишүүдийн тоо бүртгэлийг жил бүрийн Есдүгээр сарын 30-ны дотор Үндэсний Төв Штабт хүргүүлсэн байна.

б) Аймаг, Дүүргийн Скаутын Зөвлөлүүд нь Үндэсний Төв Штабт гаргаж өгсөн бүртгэлийн дагуу гишүүдийн тухайн жилийн татварыг хурааж 15 хувийг Үндэсний Төв Штабт, 85 хувийг Аймаг, Дүүргийн Скаутын Зөвлөлийн дансанд тушаасан байна.

в) Татвар төлсөн гишүүдэд тухайн жилд нь хүчинтэй байх үнэмлэх олгож байна. Үнэмлэхийг Үндэсний Төв Штабаас олгоно.

г) Насанд хүрэгчид болон Үндэсний Зөвлөлийн гишүүдийн татварыг 100% хурааж Үндэсний Зөвлөлийн хурлын өмнө ҮТШ-т тушаасан байна.

д) Монголын Скаутын Холбоо нь ДСХБ-ын гишүүнийхээ татварыг тогтоосон хэмжээгээр заасан хугацаанд нь саадгүй төлж байна.

е) Монголын Скаутын Холбооны гишүүний татвар, бусад төрлийн хураамжийн хэмжээ болон төлөх хугацаа, хэлбэр зэргийг өөрчлөн тогтоох асуудлыг Үндэсний Зөвлөлийн хурлаар тогтооно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. МОНГОЛЫН СКАУТЫН ХОЛБООНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, БҮТЭЦ

Удирдлагын түвшинд	Эрх барих байгууллага	Удирдах байгууллага	Гүйцэтгэх байгууллага
Үндэсний түвшинд	Үндэсний Зөвлөлийн хурал	Удирдах Зөвлөл	Гүйцэтгэх Захирал (Ерөнхий Нарийн Бичгийн Дарга)
Орон нутгийн түвшинд	Аймаг, дүүргийн Скаутын Зөвлөл	Аймаг, дүүргийн Скаутын Зөвлөлийн Дарга	Нарийн бичгийн дарга
Анхан шатны түвшинд	Бүлгэмийн Зөвлөл	Бүлгэмийн Удирдагч (Скаутмастер)	Бүлгийн Удирдагч

14. Монголын Скаутын Холбооны эрх барих дээд байгууллага нь Үндэсний Зөвлөлийн Хурал мөн.

15. Үндэсний Зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

- Удирдах Зөвлөлийн гишүүд
- Үндэсний Зөвлөлийн Товчооны гишүүд
- Хяналтын Зөвлөлийн гишүүд
- Аймаг, Дүүргийн Скаутын Зөвлөлийн Дарга нар

Үндэсний Зөвлөлийн гишүүд нь тэгш эрхтэй байна. Үндэсний Зөвлөлийн гишүүд нь давхар сонгууль хүлээхгүй. Үндэсний Зөвлөлийн гишүүд Үндэсний Төв Штабт давхар ажиллахгүй. Гүйцэтгэх Захирал нь Үндэсний Зөвлөлийн Нарийн Бичгийн Дарга байна.

16. Үндэсний Зөвлөлийн Гишүүдийн бүрэн эрхийн хугацаа.

1) Үндэсний Зөвлөлийн гишүүд нь 3 жилийн хугацаагаар сонгогдоно. Улиран сонгогдож болно.

2) Дор дурьдсан тохиолдолд Үндэсний Зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдөнө.

а) Тухайн гишүүнийг албан тушаал, ажил үүрэгтэй холбоотой асуудлаар хугацаанаас нь өмнө Үндэсний Зөвлөлийн гишүүнээс огцруулах тохиолдолд Удирдах Зөвлөл, Үндэсний Зөвлөлийн Товчооны хамтарсан хурлаар асуудлыг хэлэлцээд нууц санал хураалтаар нийт гишүүдийн гуравны хоёрын саналаар шийдвэрлэнэ.

б) Хуулийн байгууллагаас тухайн хүнийг гэмт хэрэгт холбогдсоныг нотолсон тохиолдолд ёс зүйн хувьд тохирохгүй гэж үзэж гишүүнээс хасна,

в) Сонгуульт ажил үүргийнхээ дагуу Үндэсний Зөвлөлд гишүүнээр сонгогдсон хүн уг сонгуульт ажлаас чөлөөлөгдсөн буюу огцорсон бол.

17. Үндэсний Зөвлөлийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:
- а) Монголын Скаутын Холбооны зорилгыг хэрэгжүүлэх асуудалтай холбогдуулан үйл ажиллагааны тайлан, цаашдын нэгдсэн бодлого, үндсэн чиглэл, хэтийн төлөвлөгөөг хэлэлцэж батална.
 - б) Ерөнхийлөгч, Удирдах Зөвлөлийн гишүүд, Үндэсний Зөвлөлийн Товчооны Гишүүд, Хяналтын Зөвлөлийн гишүүдийг сонгоно.
 - в) Монголын Скаутын Холбооны санхүү, эд хөрөнгийн талаар ерөнхий бодлого, чиглэлийг тодорхойлж, санхүүгийн жилийн тайлан тэнцэл, төсвийн төсөл зэргийг хэлэлцэж батална.
 - г) Үндэсний Зөвлөлд шинээр гишүүн элсүүлж батлах, чөлөөлөх, нөхөн сонгох шийдвэр гаргана.
 - д) Орон нутгийн болон скаутын анхан шатны скаутын байгууллагуудын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч энэхүү дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавих, эрхийг баталгаажуулах, хүчингүй болгох, тур хугацаагаар түдгэлзүүлэх шийдвэр гаргана.
 - е) Үндэсний Зөвлөлийн гишүүдийн гаргасан санал, зөвлөмжийг авч хэлэлцэнэ.
 - ё) Монголын Скаутын Холбооны дүрэмд өөрчлөлт, нэмэлт, засвар оруулах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.
18. Үндэсний Зөвлөлийн хурлыг жилд нэгээс доошгүй удаа хуралдуулна.
19. Зарлан хуралдуулах
- а) Ерөнхийлөгчийн товлож сонгосон цаг, хугацаа, байранд хуралдана. Ерөнхийлөгчийн эзгүйд Удирдах зөвлөлийн гишүүдийн олонхи нь хуралдуулж болно.
 - б) Ерөнхийлөгчийн санал болгосон буюу Удирдах Зөвлөлийн гишүүдийн гуравны нэг нь дэмжсэн асуудлыг бүх гишүүдэд захидлаар мэдэгдэн энгийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.
 - в) Хурал хуралдах газар, байр, цаг хугацаа, хэлэлцэх асуудлыг хурал эхлэхээс 30 хоногийн өмнө бичгээр Үндэсний Зөвлөлийн гишүүдэд мэдэгдэнэ.
 - г) Ээлжит бус хурал хийхээр бол Ерөнхийлөгч энэ тухай 7 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.
20. Хурал хүчин төгөлдөр болох
- а) Үндэсний Зөвлөлийн хуралд ирвэл зохих гишүүдийн энгийн олонхи хүрэлцэн ирсэн тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцно.
 - б) Шуудангаар болон бусад харилцаа холбоог ашиглан Үндэсний Зөвлөлийн хурлыг хийж болох бөгөөд хурлаар хэлэлцсэн асуудлуудаар заасан хугацааны дотор санал ирүүлээгүй тохиолдолд хэлэлцэж байгаа асуудлыг Үндэсний Зөвлөлийн гишүүд дэмжсэнд тооцно.
21. Хурлын дарга
- Хурлыг Ерөнхийлөгч, ерөнхийлөгчийн эзгүйд үндэсний зөвлөлийн хурлаас сонгогдсон хурлын тэргүүлэгчид даргална.
22. Санал хураалт
- а) Хэлэлцэж байгаа асуудлаар санал хураалтыг нууцаар болон ил явуулж болно.
 - б) Санал хуваагдвал дахин санал хураана.
23. Хурлыг хойшлуулах
- Хэлэлцэж байгаа асуудлаар гурван удаа санал хуваагдвал гишүүдийн саналыг харгалзан хурлыг түр хугацаагаар хойшлуулж болно.
24. Сонгуульт ажилд нэр дэвших
- Аливаа сонгуульт ажилд нэр дэвшүүлэхдээ тухайн хүний саналыг авч, өөрөө зөвшөөрсөн тохиолдолд сонгоно.
25. Удирдах Зөвлөл
- а) Монголын Скаутын Холбооны Удирдах Зөвлөл нь Үндэсний Зөвлөлийн хурлаас 3 жилийн хугацаагаар сонгогдох бөгөөд улиран сонгогдож болно.

- б) Удирдах зөвлөл нь 5 хүний бүрэлдэхүүнтэй байх ба Ерөнхийлөгч болон Ерөнхийлөгчийн санал болгож Үндэсний зөвлөлийн хурлаас баталсан 4 хүнээс бүрдэнэ.
- в) Удирдах Зөвлөлийн хурлыг улиралд нэгээс доошгүй удаа хуралдуулна. Хурлыг Ерөнхийлөгч даргална.
- г) Удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхи ирсэн тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцно.
- д) Хурлаас гарах шийдвэрийг олонхийн саналаар батлана. Санал тэнцсэн тохиолдолд Ерөнхийлөгчийн шийдвэр эцсийнх байна.

26. Удирдах Зөвлөл нь дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- а) Үндэсний Зөвлөлийн хурлын хооронд Монголын Скаутын Холбооны үйл ажиллагаа, санхүүтэй холбоотой асуудлыг Үндэсний Зөвлөлийн хурлаас баталсан төлөвлөгөө, төсвийн хүрээнд хэлэлцэж шийдвэрлэнэ.
- б) Төсөвт тусгагдаагүй хөрөнгө мөнгөний асуудлыг бололцоотой бол бусад эх үүсвэрээс гарган шийдвэрлэж болно.
- в) Монголын Скаутын Холбооны жилийн ажлын тайлан, санхүүгийн бүртгэл тооцоо, төсөв, төлөвлөгөөг хянаж Үндэсний Зөвлөлийн хуралд оруулна.
- г) Үндэсний Зөвлөлийн хурлаар баталсан үйл ажиллагааны нэгдсэн бодлого, чиглэлийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тодорхой чиг үүргийг гүйцэтгэх салбар хороодыг байгуулан ажиллуулж болно.
- д) Товчооны гишүүдийн ажил үүргийн хуваарийг батална.
- е) Үндэсний Төв Штабын бүтэц, зохион байгуулалт, орон тоо, ажил үүргийн хуваарийг хянаж батална.
- ё) Гүйцэтгэх Захирлыг томилж ажиллуулна.

27. Үндэсний Зөвлөлийн Товчоо

1) Үндэсний Зөвлөлийн Товчоог дараах бүрэлдэхүүнтэйгээр Үндэсний Зөвлөлийн хурлаас сонгож батлах ба улиран сонгогдож болно. Үүнд:

- а) Ерөнхийлөгч
- б) Гадаад харилцааны дарга
- в) Сургалтын дарга
- г) Хөтөлбөрийн дарга
- д) Кабын салбарын дарга
- е) Скаутын салбарын дарга
- ё) Венчирийн салбарын дарга
- ж) Роверын салбарын дарга
- з) Орон нутаг хариуцсан дарга

2) Үндэсний Зөвлөлийн Товчооны хурлыг сар тутамд нэг удаа хуралдуулах ба Товчооны гишүүдийн санал болгосны дагуу шаардлагатай үед хэдэн ч удаа хуралдаж болно. Хурлыг Ерөнхийлөгч даргалах ба Ерөнхийлөгч байхгүй үед ахмад гишүүн нь даргална.

3) Үндэсний Зөвлөлийн Товчооны гишүүдийн энгийн олонхи хүрэлцэн ирсэн тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцно.

28. Үндэсний Зөвлөлийн Товчоо нь дараах үүргийг гүйцэтгэнэ.

- а) Үндэсний Төв Штабын үйл ажиллагааг бодлого, чиглэлээр удирдана.
- б) Скаутын үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэнэ.
- в) Хороодоос гаргасан хөтөлбөр, саналуудыг авч хэлэлцэн батална.
- г) Үйл ажиллагаагаа явуулах, хөтөлбөр, бусад зүйлд шаардлагатай санхүүгийн асуудлыг Удирдах Зөвлөлд тавьж шийдвэрлүүлнэ.
- д) Шагнал урамшууллын асуудлыг шийдвэрлэж байна.
- е) Гадаадад болох арга хэмжээнд шагналын журмаар оролцох хүний асуудлыг Товчооны гишүүд болон Гүйцэтгэх захирлын санал болгосны дагуу хэлэлцэж шийдвэрлэнэ.

29. Хяналтын Зөвлөл.

- а. Хяналтын Зөвлөл нь 3 хүний бүрэлдэхүүнтэй байна.
- б. Хяналтын Зөвлөлийн Даргыг гишүүдийн хурлаас сонгож батална.
- в. Хяналтын Зөвлөл нь Монголын Скаутын Холбооны бүх шатны байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж шаардлагатай бол холбогдох байгууллагуудад асуудлыг тавьж шийдвэрлүүлж байна.
- г. Монголын Скаутын Холбооны насанд хүрэгчдийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавина.

д. Монголын Скаутын Холбоо болон Үндэсний Төв Штаб, салбар багууд, скаутын сонгуультан, албан тушаалтан, хувь хүний Скаутын үйл ажиллагаатай холбоотой санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийнэ.

е. Удирдах зөвлөл, Үндэсний Зөвлөлийн Товчооны хурлын шийдвэр, түүний хэрэгжилтийн мөрөөр хяналт шалгалт хийж байна.

ё. Улс, бүс, аймаг, дүүргийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа зуслан, цугларалт, төвлөрсөн үйл ажиллагаанд хяналт тавьж, шалгалт хийнэ.

ж. Шаардлагатай гэж үзвэл Скаутын Холбооны гишүүн хувь хүн, албан тушаалтан, байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт шалгалт хийлгүүлэхээр Үндэсний Зөвлөлийн хуралд санал оруулна.

з. Үндэсний Зөвлөлийн хуралд Хяналтын Зөвлөл нь жил бүр өөрийн ажлын тайлангаа тавьж байна.

30. Ерөнхийлөгч

а) Үндэсний Зөвлөлийн хурлаар Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрийг сонссоны үндсэн дээр хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар, нууц санал хураалтаар шийдвэрлэнэ. Ерөнхийлөгч нь дахин сонгогдож болно.

б) Ерөнхийлөгч хугацаанаасаа өмнө огцрох буюу чөлөөлөгдвөл шинэ Ерөнхийлөгч сонгогдох хүртэл Удирдах Зөвлөлийн ахмад гишүүн нь Ерөнхийлөгчийн үүргийг гүйцэтгэнэ. Үүрэг гүйцэтгэгч нь Ерөнхийлөгч эзгүйрсэнээс хойш 60 хоногийн дотор Үндэсний Зөвлөлийн хурлыг зарлан хуралдуулж Ерөнхийлөгчийг сонгоно.

31. Ерөнхийлөгч дараах үүргийг хүлээнэ.

а) Монголын Скаутын Холбооны үйл ажиллагаа, түүний хөгжлийн талаар Үндэсний Зөвлөлийн өмнө хариуцлага хүлээнэ.

б) Тус оронд Скаутын хөдөлгөөнийг хөгжүүлэх, төлөвлөх асуудлыг хариуцах ба Монголын Скаутын Холбоо, орон нутаг дахь Скаутын Зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулахад анхаарна.

в) Монголын Скаутын Холбооны Ерөнхийлөгч нь Монголын Скаутын Холбоог төлөөлөн төр, засаг, олон нийт, аж ахуй, олон улсын байгууллагуудтай харилцана.

г) Монголын Скаутын Холбооны зохион байгуулах үйл ажиллагаа, Удирдах Зөвлөл, Үндэсний Зөвлөлийн Товчоог удирдана.

д) Удирдах Зөвлөл болон Үндэсний Зөвлөлийн Товчооны гишүүдийг судлан ажиллуулах талаар Үндэсний Зөвлөлтэй зөвшилцөн сонгуулах асуудлыг хариуцна.

е) Салбар холбоодоос тавьсан асуудлыг шийдвэрлэнэ.

ж) Гадаад арга хэмжээнд оролцох төлөөлөгчдийг эцэслэн шийдвэрлэнэ.

32. Гүйцэтгэх Захирал

а) Гүйцэтгэх Захирал нь Монголын Скаутын Холбооны захиргааны бүх асуудлыг хариуцаж орон тоогоор ажиллана.

б) Захиргааны асуудал гэдэг нь:

- Үндэсний Зөвлөлийн хурлыг дүрмийн дагуу хугацаанд нь зохион байгуулна.

- Үндэсний Зөвлөлийн жилийн тайлан гаргана.

- Үндэсний Зөвлөлийн хурал, Удирдах Зөвлөл, Үндэсний Товчооны хурлаар хэлэлцэх асуудлыг Ерөнхийлөгчтэй зөвлөн бэлтгэнэ.

- Удирдах Зөвлөлаас баталсан бүтэц, зохион байгуулалтын дагуу салбар хэсгүүдийг байгуулан ажиллуулж, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулж, удирдан зохион байгуулна.

- Монголын Скаутын Холбооны бодлого, дүрмийн талаарх баримт бичгийг сүүлийн үеийн тоо баримтаар баяжуулж байна.

- Монголын Скаутын Холбооны зорилт, өсөлттэй уялдуулан олон нийттэй холбоо тогтоож байна.

- Дотоод, гадаадын хэрэгцээнд зориулан мэдээллийг холбогдох газар, хүмүүст тогтмол өгөх, сонин сэтгүүл, илтгэл бэлтгэнэ.

- Монголын Скаутын Холбооны үйл ажиллагааг Монгол Улсын хууль зүйн хүрээнд явуулна.

- Эд хөрөнгийн даатгал болон бусад зүйлийг хэвийн хэмжээнд явуулна.

- Үндэсний Зөвлөл, Удирдах Зөвлөлийн баталсан төсөв, хөрөнгийг захиран зарцуулна.

в) Аймаг, Дүүргийн Скаутын Зөвлөлийн Дарга нарыг Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний дагуу томилж ажиллуулах ба Үндэсний Зөвлөлийн хурлаар баталгаажуулна.

33. Скаут хүүхэд, залуучуудын зөвлөл

Хүүхэд, залуучуудыг шийдвэр гаргахад оролцуулах, тэдний бие даасан үйл ажиллагааг дэмжих зорилгоор Үндэсний Зөвлөлийн Товчооны дэргэд Скаутын хүүхэд, залуучуудын зөвлөлийг ажиллуулна. Зөвлөлийг Үндэсний Зөвлөлийн Товчооны хурлаар байгуулж үйл ажиллагааны журмыг батална.

34. Үндэсний Төв Штабын байр нь нийслэл Улаанбаатар хотод байх бөгөөд Үндэсний Зөвлөл, Салбар хороод, Ерөнхийлөгчийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд Гүйцэтгэх Захирал үйл ажиллагааг нь удирдана.

35. Үндэсний Төв Штабын үүрэг

- а) Монголын Скаутын Холбооны үйл ажиллагааг Монгол Улсын "Төрийн бус байгууллагын тухай" хуулийн дагуу явуулна.
- б) Дүрэм, бодлогын дагуу орон нутгийн Зөвлөлүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, дэмжлэг үзүүлж туслана.
- в) Үндэсний Зөвлөлөөр батлагдсан Монголын Скаутын Холбооны бэлгэ тэмдэг, онцлог, ёслол хүндэтгэлийн дүрэм скаутын бүх шатны байгууллагуудад хэрэгжиж буй байдалд хяналт тавина.
- г) Монголын Скаутын Холбооны жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.
- д) Скаутын бүлгэмүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулна.
- е) Бодлого, үйл ажиллагааны талаар сурталчилна.
- ё) Дэлхийн болон АНДБ-ийн Товчоотой холбогдох асуудлаар харилцана.
- ж) Монголын Скаутын Холбооны Үндэсний Зөвлөл, Удирдах Зөвлөл, Үндэсний Зөвлөлийн Товчооны хурлууд, ярилцлага, цуглаан, Жембори, зуслан, цугларалт, семинар, уулзалт, зөвлөлгөөнийг бэлтгэж, зохион байгуулахад оролцоно.
- з) Орон нутаг дахь скаутын анхан шатны нэгжүүдийг шаардлагатай мэдээ, мэдээлэл, арга зүйн материалуудаар хангана.

36. Аймаг, Дүүргийн Скаутын Зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэй байна.

- а) Аймаг, Дүүргийн Скаутын Зөвлөлийн Дарга
- б) Нарийн бичиг, олон нийттэй харилцах харилцаа хариуцсан гишүүн
- в) Сургалт, хөтөлбөр хариуцсан гишүүн
- г) Бүлгэмийн удирдагчид
- д) Санхүүгийн Дарга

37. Аймаг, Дүүргийн Скаутын Зөвлөлийн үүрэг

- а) Өөрийн аймаг, дүүрэгтээ скаутын хөдөлгөөнийг өрнүүлнэ.
- б) Зөвлөлийн Дарга, нарийн бичгийн дарга, сургалт, хөтөлбөр, үйл ажиллагааны, санхүүгийн, мэдээлэл, сурталчилгаа, олон нийттэй харилцах асуудал хариуцсан гишүүдийг сонгоно.
- в) Аймаг, Дүүргийн Скаутын Зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөөг хэлэлцэж батална.
- г) Зөвлөлийн хурлыг хагас жилд нэгээс доошгүй удаа хуралдуулна.
- д) Аймаг, дүүргийн хэмжээнд зохиогдох төвлөрсөн арга хэмжээ, аялал, зуслан, цугларалтыг зохион байгуулах шийдвэр гаргана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СКАУТЫН БҮЛГИЙН АНХАН ШАТНЫ НЭГЖҮҮД

СКАУТЫН БҮЛГЭМ

38. Монголын Скаутын Холбооны үндсэн нэгж нь Скаутын бүлгэм мөн.

- а) Скаутын бүлгэм нь каб, скаут, венчир, роверын тус бүр нэг, нэг бүлгээс бүрдэнэ.
- б) Бүлгэм нь орон нутгийн онцлог, нөхцөл байдлаас шалтгаалан 2-оос доошгүй салбарын хоёроос дээшгүй бүлгүүдээс бүрдэж болно.
- в) Бүлгэмүүд нь Үндэсний Төв Штабт бүртгүүлж гэрчилгээ авна.
- г) Гэрчилгээ авсан бүлгэм нь өөрийн харъяалагдах аймаг, дүүргийн Скаутын Зөвлөлд бүртгүүлнэ.

39. Бүлгэм бүр зөвлөлтэй байна.

40. Бүлгэмийн зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэй байна.

- а) Бүлгэмийн удирдагч (Зөвлөлийн дарга)
- б) Булгэмийн удирдагчийн туслах удирдагчид
- в) Булгийн удирдагч нар

г) Эцэг эхийн Зөвлөлийн төлөөлөгч 3 хүн

41. Бүлгэмийн Зөвлөлийн гүйцэтгэх үүрэг
- а) Бүх салбарт шинээр гишүүн элсүүлнэ.
 - б) Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах, хэрэгжүүлнэ.
 - в) Бүлгийн удирдагчдын ур чадварыг дээшлүүлэх, сургалтанд хамруулна.
 - г) Бүлгэмийн үйл ажиллагааны бүх насны скаутын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.
 - д) Бүлгэмийн эд хөрөнгийг хамгаалан арвижуулна.
 - е) Хөрөнгө хуримтлуулна.
 - ж) Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд туслах хүмүүсийг олно.
 - з) Олон түмэнтэй харилцаа тогтоох, зуслан, цугларалт зохион байгуулна.
 - и) Жил бүр хуралдаж үйл ажиллагааны тайлан, санхүүгийн төсөв, гүйцэтгэлийг хэлэлцэж батална.
42. Бүлгэмийн удирдагчид, түүний туслах удирдагчид
- а) Бүлгэмийн удирдагч нь бүлгэмийн Зөвлөлийг удирдана.
 - б) Бүлгэмийн удирдагч нь хариуцсан бүлгэмийнхээ бүхий л үйл ажиллагааг зохицуулах үүрэгтэй.
 - в) Бүлгэмийн зохион байгуулалт, санхүүгийн асуудлыг хариуцаж хяналт тавина.
 - г) Бүлгэмийн туслах удирдагчид болон бүлгийн удирдагчийг томилно.
 - д) Бүлгэмийн хэмжээнд зохиогдох аялал, зуслан, цугларалтын зөвшөөрөл олгоно.
43. Бүлгэм татан буугдах тухай
- а) Дүрмийн 41 дүгээр зүйлийн а, б, в заалтууд зөрчигдсөн тохиолдолд
 - б) Скаутын үйл ажиллагаа тогтмол явагдаж чадахгүй байна гэж Аймаг, Дүүргийн Скаутын Зөвлөл. Үндэсний Төв Штаб үзсэн тохиолдолд Үндэсний Зөвлөлийн Товчооны хурлын тогтоолоор татан буугдана.
45. Кабын бүлэг
- а) Кабын бүлэг нь 18-24 гишүүнтэй байна.
 - б) Зургаат: Кабын энэ бүлгийн гурав буюу дөрвөн салаанд хуваагдана. Салаа бүр нь 6 кабаас бүрдэх бөгөөд түүнийг зургаат гэж нэрлэнэ.
 - в) Зургаатын дарга нарын ахлагч: Ахлагчийг кабын бүлгийн Удирдагч томилно.
 - г) Зургаатын дарга: Зургаан кабыг удирдах даргыг кабын бүлгийн удирдагч томилно.
 - д) Зургаатын даргын орлогч: Зургаатын даргын орлогчийг зургаатын дарга өөрөө шилж сонгоно.
- 46 Кабын бүлгийн удирдагч, түүний туслах удирдагчид
- а) Кабын бүлгийг хариуцсан ахмад хунийг кабын удирдагч гэх ба зургаатыг хариуцсан насанд хүрэгчдийг түүний туслах удирдагчид гэнэ.
 - б) Кабын бүлгийн удирдагч, түүний туслах удирдагчдыг бүлгэмийн удирдагч томилно. Кабын бүлгийн удирдагч, түүний туслах удирдагчид кабын бүлгийн удирдах анхан шатны мэдлэг эзэмшсэн, скаутын хууль, зарчим, арга, бодлого, дүрэм журмын талаар тодорхой мэдэгдэхүүнтэй байх ёстой.
47. Кабын бүлгийн Зөвлөл
- а) Зөвлөл нь Бүлгийн удирдагч, тууний туслах удирдагчид, эцэг эхийн төлөөлөгч 1-2 хүнээс бүрдэнэ.
 - б) Бүлгийн ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.
48. Скаутын бүлэг
- а) Скаутын бүлэг нь 18-36 скаутаас бүрдэнэ.
 - б) Бүлэг нь дотроо хоёроос дөрвөн салаанд хуваагдаж, салаа бүр 5-9 хүртэл гишүүнтэй байна.
49. Скаутын бүлгийн удирдагч
- а) Скаутын бүлгийн ажлыг хариуцах насанд хурсэн хүнийг скаутын бүлгийн удирдагч, туслах удирдагч гэнэ.
 - б) Скаутын бүлгийн удирдагч, тууний туслах удирдагчид нь скаутын бүлгийн удирдагч нарт зориулсан сургалтанд оролцож, зохих мэдлэгтэй болсон байна.

50. Скаутын бүлгийн Зөвлөл
а) Зөвлөл нь Бүлгийн удирдагч, түүний туслах удирдагчид, эцэг эхийн төлөөлөгч 1-2 хүнээс бүрдэнэ.
б) Бүлгийн ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.
51. Венчирийн бүлэг
а) Венчирийн бүлэг нь 10-18 венчирүүдээс бүрдэнэ.
б) Бүлэг нь дотроо хоёроос гурван салаанд хуваагдаж, салаа бүр 5-9 хүртэл гишүүнтэй байна.
52. Венчирийн бүлгийн удирдагч
а) Венчирийн бүлгийн ажлыг хариуцах насанд хүрсэн хүнийг Венчирийн бүлгийн удирдагч, туслах удирдагч гэнэ.
б) Венчирийн бүлгийн удирдагч, түүний туслах удирдагчид нь скаутын бүлгийн удирдагч нарт зориулсан сургалтанд оролцож, зохих мэдлэгтэй болсон байна.
53. Венчирийн бүлгийн Зөвлөл
а) Зөвлөл нь Бүлгийн удирдагч, түүний туслах удирдагчид, эцэг эхийн төлөөлөгч 1-2 хүнээс бүрдэнэ.
б) Бүлгийн ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.
54. Роверын бүлэг
а) Роверын бүлэг нь 6-аас дээш гишүүнтэй байна.
б) Роверын бүлгийг тэдний дундаас сонгогдсон ровер удирдана.
55. Роверын салбарын дүрэм нь энэ дүрмийн нэмэлт дүрэм болно.
56. Тусгай скаутууд
Тусгай скаутууд гэж эрүүл мэнд, мэдрэлийн өвчин зэрэг шалтгаанаар скаутын хэвийн үйл ажиллагаанд оролцож чадахгүй болсон хүмүүсийг хэлнэ. Тахир дутуугийн шалтгаанаар ямар нэг шалгалтыг өгч чадахгүй бол Үндэсний Төв Штабаас боловсруулсан тусгай хөтөлбөрийн дагуу ийм хүүхдийг гишүүнээр элсүүлнэ. Гишүүн нь Скаутын байгууллагын бүрэлдэхүүн хэсэг болж каб, скаут, венчир, роверын ердийн бүлэг, салаанд харъяалагдана.
55. Тайлан, тооцоо.
Скаутын сан, мөнгөн хөрөнгийг банкинд хадгалах бөгөөд холбогдох зөвшөөрлөөр бүх гүйлгээг гүйцэтгэнэ. Гүйлгээг Гүйцэтгэх Захирал, Салбар багийн дарга, санхүүч нар гүйцэтгэнэ.
Санхүүгийн тайланг сар, улирал, жилээр гаргаж Удирдах Зөвлөлд тайлагнана. Санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД ЗҮЙЛ

56. Өөрчлөлт
а) Үндэсний Зөвлөлийн хуралд оролцсон гишүүдийн гуравны хоёр хувийн саналаар дүрэмд өөрчлөлт, засвар хийж болно. Өөрчлөлт, засварын тухай Үндэсний Зөвлөлийн бүх гишүүдэд Үндэсний Зөвлөлийн хурал эхлэхээс 30 хоногийн өмнө мэдэгдсэн байна.
б) Санал болгосон өөрчлөлт, засварыг хэлэлцэх асуудлын хамтаар тараах бөгөөд эдгээр өөрчлөлт, засварыг ээлжит бус хурлаар шийдвэрлэж болохгүй.
в) Оруулах өөрчлөлт, засварын талаар Дэлхийн Скаутын Хөдөлгөөний хуулийн тавдугаар зүйлийн 3-т заасны дагуу Дэлхийн Скаутын Товчоонд мэдэгдэж байна.
г) Дүрэмд орох зарчмын өөрчлөлтийг энэхүү дүрмийн нэмэлт болгон батална.